



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/06

Мандхговь

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан суманд гарсан мал, амьтны гоц халдаварт "Шүлхий" өвчний голомт хүрээгээ тэлж Цагаандэлгэр, Говь-угтаал сумдад гарсан тул дээрх сумдыг 2018 оны 01 сарын 02-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсугай.

Хоёр. Дээрх сумдтай хил залгаа Дэрэн, Гурвансайхан, Өндөршил сумын Засаг дарга нарт энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

Гурав. Цагаандэлгэр Говь-угтаал, Гурвансайхан сумын шуудан тээврийн хөдөлгөөн, Өлзийт, Хулд, Гурвансайхан, Дэлгэрхангай, Баянжаргалан сумдаас тээвэрлэж буй уул уурхайн баяжмал бүхий тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорио цээрийн дэглэм бууртал түр хугацаагаар хориглосугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/, Цагдаагийн газар /Н.Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200011